ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шинжилгээний албаны  2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/193/СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитор: Д.Пүүжмаа
Утас:92038288
Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ........ **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5
3. Аудитын тайлан........ 11
3.1 Ерөнхий зүйл........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
3.4 Материаллаг байдал ........ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........ 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........ 13
3.8 Аудитын гол асуудал ........ 13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........ 13
4. Аудитын илрүүлэлт ........ 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1302/392

танай ____________-ны № ____________-т

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА Ж.ДАВААДОРЖ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

01?0?5431

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| ORT_I | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 5,415,850.00 | 14,392,191.00 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 5,415,850.00 | 14,392,191.00 |
| 61 | Түүхий эд материал | 2,669,600.00 | 7,744,140.00 |
| 62 | Тусгай зориулалттай материал | 1,569,000.00 | 6,749,000.00 |
| 63 | Эм боох материал | 1,100,600.00 | 995,140.00 |
| 66 | Хангамжийн материал | 2,746,250.00 | 6,648,051.00 |
| 67 | Бичиг хэргийн материал | 210,850.00 | 129,000.00 |
| 68 | Аж ахуйн материал | 2,535,400.00 | 6,519,051.00 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 61,072,998.33 | 47,895,193.34 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 61,072,998.33 | 47,895,193.34 |
| 108 | Биет хөрөнгө | 56,822,998.33 | 43,645,193.34 |
| 111 | Авто тээврийн хэрэгсэл | 41,900,000.00 | 41,900,000.00 |
| 112 | Хуримтлагдсан элэгдэл | (9,512,500.09) | (17,329,166.77) |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 44,686,989.48 | 47,686,989.48 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (23,272,182.57) | (30,748,456.60) |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,122,754.58 | 7,122,754.58 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (4,102,063.07) | (4,986,927.35) |
| 122 | Бусад үндсэн хөрөнгө | 1,144,000.00 | 1,144,000.00 |
| 123 | Хуримтлагдсан элэгдэл | (1,144,000.00) | (1,144,000.00) |
| 126 | Биет бус хөрөнгө | 4,250,000.00 | 4,250,000.00 |
| 131 | Газар эзэмших эрх | 4,250,000.00 | 4,250,000.00 |
| 138 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 66,488,848.33 | 62,287,384.34 |
| 139 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | (0.00) | (0.00) |
| 140 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | (0.00) | (0.00) |
| 165 | Өглөг | (0.00) | (0.00) |
| 166 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | (0.00) | (0.00) |
| 215 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 66,488,848.33 | 62,287,384.34 |
| 216 | Засгийн газрын хувь оролцоо | 66,488,848.33 | 62,287,384.34 |
| 217 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн са | 10,550,000.00 | 10,550,000.00 |
| 218 | Өмч: -Төрийн өмч | 10,550,000.00 | 10,550,000.00 |
| 224 | Хуримтлагдсан үр дүн | 55,938,848.33 | 51,737,384.34 |
| 225 | Өмнөх үеийн үр дүн | 55,938,848.33 | 55,938,848.33 |
| 226 | Тайлант үеийн үр дүн | - | (4,201,463.99) |
| 232 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 66,488,848.33 | 62,287,384.34 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

# САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| | | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 224,051,284.99 | 241,631,401.00 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 23,808,584.99 | 8,117,501.00 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 23,808,584.99 | 8,117,501.00 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 23,808,584.99 | 8,117,501.00 |
| 82 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,819,600.00 | 5,117,501.00 |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 18,988,984.99 | 3,000,000.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 200,242,700.00 | 233,513,900.00 |
| 112 | Улсын төвлөрсөн төсвөөс | 199,242,700.00 | 233,013,900.00 |
| 113 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 199,242,700.00 | 228,013,900.00 |
| 114 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | 5,000,000.00 |
| 122 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 500,000.00 |
| 125 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | - | 500,000.00 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 214,372,372.89 | 245,832,864.99 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 214,372,372.89 | 245,832,864.99 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 214,093,730.57 | 245,656,597.88 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 176,702,176.26 | 197,664,161.33 |
| 151 | Цалин | 102,093,456.36 | 188,215,753.33 |
| 152 | Нэмэгдэл цалин | 59,344,719.90 | 9,448,408.00 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,264,000.00 | - |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,537,181.42 | 4,769,471.56 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 3,537,181.42 | 4,769,471.56 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 14,863,550.00 | 15,966,700.00 |
| 171 | Бичиг хэргийн материал | 1,225,000.00 | 2,081,850.00 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 10,746,600.00 | 10,000,000.00 |
| 173 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 1,191,500.00 | 1,130,000.00 |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 1,700,450.00 | 2,754,850.00 |
| 181 | Нормативт зардал | 2,635,700.00 | 5,593,460.00 |
| 182 | Эм | 2,635,700.00 | 5,093,460.00 |
| 183 | Хоол | - | 500,000.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 800,000.00 | 375,000.00 |
| 188 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 444,700.00 | 375,000.00 |
| 189 | Урсгал засвар | 355,300.00 | - |
| 190 | Томилолт, зочны зардал | 3,762,100.00 | 3,000,000.00 |
| 192 | Дотоод томилолтын зардал | 3,762,100.00 | 3,000,000.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 792,400.00 | 2,110,000.00 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 383,900.00 | 2,000,000.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 300,000.00 | - |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | 50,000.00 | 50,000.00 |
| 199 | Тээврийн хэрэсглийн оношилгоо | 20,000.00 | 20,000.00 |
| 201 | Газрын төлбөр | 38,500.00 | 40,000.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,000,622.89 | 16,177,804.99 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,000,622.89 | 16,177,804.99 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 278,642.32 | 176,267.11 |
| 237 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 278,642.32 | 176,267.11 |
| 240 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 278,642.32 | 176,267.11 |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 9,678,912.10 | (4,201,463.99) |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 9,678,912.10 | (4,201,463.99) |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **10,550,000.00** | **00.00** | **55,938,848.33** | **00.00** | 66,488,848.33 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **10,550,000.00** | **00.00** | **55,938,848.33** | **00.00** | 66,488,848.33 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **10,550,000.00** | **00.00** | **55,938,848.33** | **00.00** | 66,488,848.33 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -4,201,463.99 | 00.00 | -4,201,463.99 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **10,550,000.00** | **00.00** | **51,737,384.34** | **00.00** | 62,287,384.34 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 205,062,300.00 | 238,631,401.00 |
| 77 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,819,600.00 | 5,117,501.00 |
| 78 | Нийтлэг татварын бус орлого | 4,819,600.00 | 5,117,501.00 |
| 82 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 4,819,600.00 | 5,117,501.00 |
| 83 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,819,600.00 | 5,117,501.00 |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 200,242,700.00 | 233,513,900.00 |
| 111 | Улсын төвлөрсөн төсвөөс | 199,242,700.00 | 233,013,900.00 |
| 112 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 199,242,700.00 | 228,013,900.00 |
| 113 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | 5,000,000.00 |
| 121 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 500,000.00 |
| 124 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | - | 500,000.00 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 205,062,300.00 | 238,631,401.00 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 205,062,300.00 | 238,631,401.00 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 204,783,657.68 | 238,455,133.89 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 176,047,896.90 | 197,664,161.33 |
| 151 | Үндсэн цалин | 101,439,177.00 | 116,761,561.33 |
| 152 | Нэмэгдэл | 59,344,719.90 | 64,366,600.00 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,264,000.00 | 16,536,000.00 |
| 157 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 4,191,460.78 | 4,769,471.56 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 4,191,460.78 | 4,769,471.56 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 15,079,300.00 | 19,973,501.00 |
| 171 | Бичиг хэрэг | 1,250,900.00 | 2,000,000.00 |
| 172 | Тээвэр, шатахуун | 10,746,600.00 | 10,000,000.00 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,173,400.00 | 1,310,000.00 |
| 176 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,908,400.00 | 6,663,501.00 |
| 181 | Нормативт зардал | 3,092,400.00 | 5,488,000.00 |
| 182 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,092,400.00 | 4,988,000.00 |
| 183 | Хоол, хүнс | - | 500,000.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,800,000.00 | 450,000.00 |
| 186 | Багаж техник хэрэгсэл | 1,000,000.00 | - |
| 188 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | 444,700.00 | 450,000.00 |
| 189 | Урсгал засвар | 355,300.00 | - |
| 190 | Томилолт, зочны зардал | 3,762,100.00 | 3,000,000.00 |
| 192 | Дотоод албан томилолт | 3,762,100.00 | 3,000,000.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 810,500.00 | 7,110,000.00 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 402,000.00 | 7,000,000.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | - |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | 50,000.00 | 50,000.00 |
| 199 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 20,000.00 |
| 201 | Газрын төлбөр | 38,500.00 | 40,000.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 278,642.32 | 176,267.11 |
| 234 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 278,642.32 | 176,267.11 |
| 237 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 278,642.32 | 176,267.11 |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | (0.00) | - |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

# ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 203,834,300.00 | 204,783,657.68 | 230,113,900.00 | 230,041,632.89 | 72,267.11 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 203,834,300.00 | 204,783,657.68 | 230,113,900.00 | 230,041,632.89 | 72,267.11 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 203,834,300.00 | 204,783,657.68 | 230,113,900.00 | 230,041,632.89 | 72,267.11 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 176,047,900.00 | 176,047,896.90 | 197,664,200.00 | 197,664,161.33 | 38.67 |
| 6 | Үндсэн цалин | 100,645,900.00 | 101,439,177.00 | 116,761,600.00 | 116,761,561.33 | 38.67 |
| 7 | Нэмэгдэл | 60,138,000.00 | 59,344,719.90 | 64,366,600.00 | 64,366,600.00 | - |
| 8 | Унаа, болон бусад нөхөн олговор | 15,264,000.00 | 15,264,000.00 | 16,536,000.00 | 16,536,000.00 | - |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,242,100.00 | 4,191,460.78 | 4,841,700.00 | 4,769,471.56 | 72,228.44 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 4,242,100.00 | 4,191,460.78 | 4,841,700.00 | 4,769,471.56 | 72,228.44 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 15,079,300.00 | 15,079,300.00 | 17,060,000.00 | 17,060,000.00 | - |
| 23 | Бичиг хэрэг | 1,250,900.00 | 1,250,900.00 | 2,000,000.00 | 2,000,000.00 | - |
| 24 | Тээвэр (шатахуун) | 10,746,600.00 | 10,746,600.00 | 10,000,000.00 | 10,000,000.00 | - |
| 25 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 1,173,400.00 | 1,173,400.00 | 1,310,000.00 | 1,310,000.00 | - |
| 28 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 1,908,400.00 | 1,908,400.00 | 3,750,000.00 | 3,750,000.00 | - |
| 30 | Нормативт зардал | 3,092,400.00 | 3,092,400.00 | 4,988,000.00 | 4,988,000.00 | - |
| 31 | Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл | 3,092,400.00 | 3,092,400.00 | 4,988,000.00 | 4,988,000.00 | - |
| 34 | Эд хогшил худалдан авах | 800,000.00 | 800,000.00 | | | |
| 37 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 444,700.00 | 444,700.00 | 450,000.00 | 450,000.00 | |
| 38 | Урсгал засвар | 355,300.00 | 355,300.00 | 450,000.00 | 450,000.00 | |
| 39 | Томилолт, зочны зардал | 3,762,100.00 | 3,762,100.00 | 3,000,000.00 | 3,000,000.00 | |
| 41 | Дотоод албан томилолт | 3,762,100.00 | 3,762,100.00 | 3,000,000.00 | 3,000,000.00 | |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 810,500.00 | 810,500.00 | 2,110,000.00 | 2,110,000.00 | |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 402,000.00 | 402,000.00 | 2,000,000.00 | 2,000,000.00 | |
| 45 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 300,000.00 | 300,000.00 | - | | |
| 47 | Тээврийн хэрэгслийн татвар | 50,000.00 | 50,000.00 | 50,000.00 | 50,000.00 | |
| 48 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 20,000.00 | 20,000.00 | 20,000.00 | 20,000.00 | |
| 50 | Газрын төлбөр | 38,500.00 | 38,500.00 | 40,000.00 | 40,000.00 | |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 203,834,300.00 | 205,062,300.00 | 230,113,900.00 | 230,217,900.00 | (104,000.00) |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 199,242,700.00 | 199,242,700.00 | 228,013,900.00 | 228,013,900.00 | |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 199,242,700.00 | 199,242,700.00 | 228,013,900.00 | 228,013,900.00 | |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | | - | - | |
| 104 | Орон нутгийн төсвөөс | - | | - | - | |
| 110 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 4,591,600.00 | 4,819,600.00 | 2,100,000.00 | 2,204,000.00 | (104,000.00) |
| 111 | Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,591,600.00 | 4,819,600.00 | 2,100,000.00 | 2,204,000.00 | (104,000.00) |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | | | |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | | | |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 12.00 | 12.00 | 13.00 | 13.00 | - |
| 134 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | - |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 | 12.00 | 12.00 | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

# ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,413,501.00 | 8,413,501.00 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 8,413,501.00 | 8,413,501.00 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 8,413,501.00 | 8,413,501.00 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 2,913,501.00 | 2,913,501.00 |
| 28 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 2,913,501.00 | 2,913,501.00 |
| 30 | Нормативт зардал | 500,000.00 | 500,000.00 |
| 32 | Хоол, хүнс | 500,000.00 | 500,000.00 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,413,501.00 | 3,413,501.00 |
| 110 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 2,913,501.00 | 2,913,501.00 |
| 111 | Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,913,501.00 | 2,913,501.00 |
| 120 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 500,000.00 | 500,000.00 |
| 123 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 | 500,000.00 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 13.00 | 13.00 |
| 134 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 |
| 138 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - |
| 148 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Д.Пүүжмаа, ахлах аудитор Б.Дагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн ... дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн шинжилгээний алба нь Шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн боловсронгуй орчин, оновчтой зохион байгуулалт, баталгаатай арга зүй, техник-технологийн дэвшлийг бүрэн ашиглах нөхцөлийг бий болгон, хүний нөөцийн чадварлаг баг бүрдүүлснээр аливаа хэргийг шинжлэх ухаанч нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулан мөрдөн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 245,832.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4,916.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (80 хувиар) буюу 3,933.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 5,415.8 | 14,392.2 | 8,976.4 |
| Үндсэн хөрөнгө | 61,072.9 | 47,895.2 | -13,177.7 |
| **Нийт хөрөнгө** | 66,488.8 | 62,287.4 | -4,201.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 66,488.8 | 62,287.4 | -4,201.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 66,488.8 | 62,287.4 | -4,201.4 |

Бараа материалын дансны үлдэгдэл 8,976.4 мянган төгрөгөөр өссөн нь түүхий эд материал 5,074.5 мянган төгрөгөөр, хангамжийн материал 3,901.8 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,177.7 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зарлтай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,201.4 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 230,113.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 230,113.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 228,013.9 мянган төгрөгийг,үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,204.0 мянган төгрөгийн, нийт 230,041.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл

ажиллагаанд 229,865.4 мянган төгрөгийг зарцуулж, 176.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд үйл ажиллагааны орлогоос давсан орлого 2,913.5 мянган төгрөгийг, Засаг даргын нөөц сангаас 5,500.0 мянган төгрөгийн дэмжлэг авч нийт 8,413.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт орлогоос 5,000.0 мянган төгрөгийг Фоторобот программ худалдан авахад, 3,413.5 мянган төгрөгийг аж ахуйн болон хоол хүнсний зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй байна

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа хоцроосон 14 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээллээс харахад хугацаа хоцроон мэдээлж байгаа нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,338.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,338.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа байхгүй

### 4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *3,338.7 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримт /и-баримт/-ыг бүрэн бүрдүүлээгүй;*

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;*

***2. Шилэн данстай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

*2.2. Шилэн дансны цахим цэсэд 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа хоцроосон 14 мэдээлэл байна*

*2.3. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

- ✓ *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1. | Шүүхийн шинжилгээний алба | 2 | 3.3 | | | | | | | 2 | 2 |